МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 09 сарын 25 өдөр Дугаар А/153 Улаанбаатар хот

Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон Эдийн засаг, хөгжлийн яамны шагнал олгох журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3 дахь хэсэг, 2019 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалтын 41-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон Эдийн засаг, хөгжлийн яамны шагнал олгох журам"-ын 1.3 дахь заалтын "в"-д заасан "Шинжлэх ухааны салбарын мэргэжлээр хүний нөөцийг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, 3 болон түүнээс дээш судлаачийн эрдмийн ажлыг удирдаж, докторын зэрэг хамгаалуулсан их, дээд сургуулийн эрдэмтэн, багш, судлаач" гэснийг "Шинжлэх ухааны салбарын мэргэжлээр хүний нөөцийг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, 3 болон түүнээс дээш судлаачийн эрдмийн ажлыг удирдсан дээд боловсролын сургалтын байгууллагын эрдэмтэн, багш, судлаач" гэж өөрчилсүгэй.

2. Энэхүү тушаалаар оруулсан өөрчлөлт нь Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон Эдийн засаг, хөгжлийн яамны шагнал олгох журмын нэгэн адил хүчинтэй үйлчилнэ.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР

152601000370